



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/62

Булган сум

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 11 дүгээр зүйлийн 11.5, 11.11 дэх заалт, Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн "Зөвлөлдөх санал асуулга явуулах тухай" 80 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Зөвлөлдөж шийдье" санал асуулгын үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүдэд: Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)  
Л.Ганбаатар (Цагдаагийн газрын дарга)  
А.Нарантуяа (Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)

2. "Зөвлөлдөж шийдье" санал асуулгын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Эрдэнэбилэг) -д үүрэг болгосугай.

3. 2-р шатны санал асуулгад оролцох иргэдийн аюулгүй байдлыг хангаж ирц бүрэн хамрагдуулж оролцуулахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6330011201